



## ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг  
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12  
E-mail: [khentii@audit.gov.mn](mailto:khentii@audit.gov.mn)

2022.03.04 № 106  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Аудитын санал дүгнэлт гаргах тухай

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Баянмөнх сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Баянмөнх сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭРДЭНЭБААТАР

023030148

E:/DOTOOD AJIL/БХ 2022/явсан бичиг/А4 20220304 70



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Баянмөнх сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХЭА-2022/57/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Чингис хот

2022 он

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар  
Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа  
Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Ахлах аудитор: Н.Туяа  
Утас: 99799709 Цахим хаяг: tuyan@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Contents

|   |                                       |
|---|---------------------------------------|
| Contents.....   | 1                                     |
| <b>1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....</b>                               | <b>3</b>                              |
| <b>2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....</b>           | <b>4</b>                              |
| <b>2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....</b>                   | <b>4</b>                              |
| <b>2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....</b>                | <b>5</b>                              |
| <b>2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....</b>      | <b>7</b>                              |
| <b>2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....</b>                     | <b>8</b>                              |
| <b>2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....</b>                  | <b>10</b>                             |
| <b>2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....</b>           | <b>11</b>                             |
| <b>3. Аудитын тайлан .....</b>  | <b>12</b>                             |
| 3.1 Ерөнхий зүйл.....   | 12                                    |
| 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....                      | 12                                    |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....                            | 13                                    |
| 3.4 Материаллаг байдал .....  | 13                                    |
| 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....                                  | 13                                    |
| 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....                      | 14                                    |
| 3.7 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал..... | 15                                    |
| 3.7.1 Шилэн дансны тухай хүүлийн хэрэгжилт .....                          | 15                                    |
| 3.9 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....               | 15                                    |
| 3.10 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....                            | 15                                    |
| <b>4. Аудитын илрүүлэлт .....</b>   | <b>15</b>                             |
| 4.2 Албан шаардлага .....   | 15                                    |
| 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл                               | 16                                    |
| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....    | 16                                    |
| <b>6. Аудитын тайлангийн хавсралт.....</b>                                | <b>16</b>                             |
| <b>6.1. Албан шаардлага 2021.03.04 №01</b>                                | <b>ХЭА-2022/57/НА-СТА-ТШЗ..... 16</b> |

**Товчилсон үгийн жагсаалт**

|          |   |
|----------|---|
| АДБОУС   | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт               |
| ИТХ      | Иргэдийн төлөөлөгчдийн хурал                                |
| СТА      | Санхүүгийн тайлангийн аудит                                 |
| ТШЗ      | Төсвийн шууд захирагч                                       |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт

ХЭНТИЙ АЙМГИЙН БАЯНМӨНХ СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
О.БАТБААТАР ТАНАА

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Баянмөнх сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Баянмөнх сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭРДЭНЭБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт   | Эхний үлдэгдэл             | Эцсийн үлдэгдэл            |
|------------|---|----------------------------|----------------------------|
| <b>1</b>   | <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>  | <b><u>3,574,800.00</u></b> | <b><u>5,153,300.00</u></b> |
| <b>34</b>  | <b>УРЬДЧИЛГАА</b>   | 600,000.00                 | -                          |
| 34600      | Урьдчилж гарсан зардал  | 600,000.00                 | -                          |
| <b>35</b>  | <b>БАРАА МАТЕРИАЛ</b>   | 2,974,800.00               | 5,153,300.00               |
| <b>354</b> | <b>Хангамжийн материал</b>  | 2,974,800.00               | 5,153,300.00               |
| 35410      | Бичиг хэргийн материал  | 1,204,900.00               | 1,940,400.00               |
| 35420      | Аж ахуйн материал   | 1,194,000.00               | 2,127,000.00               |
| 35470      | Бусад хангамжийн материал   | 575,900.00                 | 1,085,900.00               |
| <b>2</b>   | <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>                                    | <b><u>2,090,121.24</u></b> | <b><u>1,511,939.40</u></b> |
| <b>39</b>  | <b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>   | 2,090,121.24               | 1,511,939.40               |
| <b>392</b> | <b>Биет хөрөнгө</b>   | 2,090,121.24               | 1,511,939.40               |
| 39205      | Машин тоног төхөөрөмж (компьютер)                                     | 3,154,000.00               | 3,154,000.00               |
| 39206      | Хуримтлагдсан элэгдэл   | (1,141,878.76)             | (1,642,060.60)             |
| 39214      | Бусад үндсэн хөрөнгө  | 36,556.00                  | 36,556.00                  |
| 39215      | Хуримтлагдсан элэгдэл   | (36,556.00)                | (36,556.00)                |
| 39217      | Ном   | 78,000.00                  | -                          |
| <b>3</b>   | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>                                    | <b><u>5,664,921.24</u></b> | <b><u>6,665,239.40</u></b> |
| <b>4</b>   | <b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>   | <b><u>29,679.96</u></b>    | <b>-</b>                   |
| <b>41</b>  | <b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>                                      | 29,679.96                  | -                          |
| <b>413</b> | <b>Өглөг</b>  | 29,679.96                  | -                          |
| 41310      | Ажилчидтай холбогдсон өглөг   | 29,679.96                  | -                          |
| <b>5</b>   | <b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>                                       | <b><u>5,635,241.28</u></b> | <b><u>6,665,239.40</u></b> |
| <b>51</b>  | <b>Засгийн газрын хувь оролцоо</b>                                    | 5,635,241.28               | 6,665,239.40               |
| 511        | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,599,496.00               | 1,599,496.00               |
| 51101      | Өмч: - төрийн   | 1,599,496.00               | 1,599,496.00               |
| <b>512</b> | <b>Хуримтлагдсан үр дүн</b>   | 3,715,423.33               | 4,745,421.45               |
| 51210      | Өмнөх үеийн үр дүн  | 3,715,423.33               | 3,715,423.33               |
| 51220      | Тайлант үеийн үр дүн  | -                          | 1,029,998.12               |
| 51300      | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                                      | 320,321.95                 | 320,321.95                 |
| <b>6</b>   | <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>                    | <b><u>5,664,921.24</u></b> | <b><u>6,665,239.40</u></b> |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код  | Үзүүлэлт   | Өмнөх оны гүйцэтгэл  | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|----------------------|-----------------------|
| <b>1</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>   | <b>62,317,200.00</b> | <b>61,284,900.00</b>  |
| <b>12</b>   | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>   | -                    | <b>78,000.00</b>      |
| <b>120</b>  | <b>Нийтлэг татварын бус орлого</b>   | -                    | 78,000.00             |
| 120004      | Төсөв байгууллагын өөрийн орлого   | -                    | 78,000.00             |
| 1200045     | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого  | -                    | 78,000.00             |
| <b>13</b>   | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>   | <b>62,317,200.00</b> | <b>61,206,900.00</b>  |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>   | 4,000,000.00         | 3,300,000.00          |
| 131104      | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,000,000.00         | 3,300,000.00          |
| <b>1320</b> | <b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>  | 58,317,200.00        | 57,906,900.00         |
| 132001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/  | 58,317,200.00        | 57,906,900.00         |
| <b>2</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>   | <b>60,658,894.94</b> | <b>60,176,901.88</b>  |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | <b>60,658,894.94</b> | <b>60,176,901.88</b>  |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>   | 56,376,272.05        | 55,082,368.88         |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>   | 44,164,657.00        | 41,134,262.29         |
| 210101      | Үндсэн цалин   | 24,868,044.12        | 25,049,181.72         |
| 210102      | Нэмэгдэл   | 10,915,925.62        | 10,295,987.57         |
| 210103      | Унаа хоолны хөнгөлөлт  | 466,120.00           | -                     |
| 210104      | Урамшуулал   | 7,914,567.26         | 5,789,093.00          |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>  | 5,471,200.07         | 5,303,324.75          |
| 210201      | Тэтгэврийн даатгал   | 3,809,956.46         | 3,691,022.24          |
| 210202      | Тэтгэмжийн даатгал   | 408,918.31           | 411,397.44            |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал  | 335,808.63           | 329,117.93            |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал   | 93,783.88            | 74,319.51             |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал  | 822,732.79           | 797,467.63            |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>  | 3,116,400.00         | 2,420,900.00          |
| 210401      | Бичиг хэрэг  | 730,100.00           | 372,800.00            |
| 210402      | Тээвэр, шатахуун   | 2,176,200.00         | 1,841,100.00          |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр   | 120,100.00           | 135,000.00            |
| 210405      | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал  | -                    | 72,000.00             |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс  | 90,000.00            | -                     |
| <b>2107</b> | <b>Томиллолт, зочны зардал</b>   | 626,000.00           | 657,000.00            |
| 210702      | Дотоод албан томиллолт   | 626,000.00           | 657,000.00            |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>  | 2,438,000.00         | 2,106,700.00          |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж                                       | 2,114,000.00         | 1,782,700.00          |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>   | 560,014.98           | 3,460,181.84          |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх  | 60,000.00            | 2,960,000.00          |
| 210903      | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол   | 500,014.98           | 500,181.84            |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | 4,282,622.89         | 5,094,533.00          |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>  | 990,000.00           | 1,310,000.00          |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал  | 990,000.00           | 1,310,000.00          |
| <b>2133</b> | <b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>   | 2,924,022.89         | 3,610,033.00          |
| 213303      | Төвлөрүүлэх шилжүүлэг  | 2,924,022.89         | 3,610,033.00          |

|            |  |                            |                            |
|------------|--|----------------------------|----------------------------|
| 2134       | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 368,600.00                 | 174,500.00                 |
| 213403     | Төвлөрүүлэх шилжүүлэг  | 368,600.00                 | 174,500.00                 |
| <b>3</b>   | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>                            | <b><u>1,658,305.06</u></b> | <b><u>1,107,998.12</u></b> |
| <b>225</b> | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>                               | -                          | 78,000.00                  |
| 225001     | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз                                       | -                          | 78,000.00                  |
| <b>4</b>   | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>                      | -                          | (78,000.00)                |
| <b>5</b>   | <b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>                                       | <b><u>1,658,305.06</u></b> | <b><u>1,029,998.12</u></b> |

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

| Код | Үзүүлэлт   | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн   | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|---------------------|--|
| D01 | <b>2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>       | <b>1,599,496.00</b>             | <b>320,321.95</b>     | <b>3,715,423.33</b> | <b>5,635,241.28</b>                    |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт       | -                               | -                     | -                   | -                                      |
| D03 | <b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>                | -                               | -                     | -                   | -                                      |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | -                               | -                     | -                   | -                                      |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт                  | -                               | -                     | -                   | -                                      |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз    | -                               | -                     | -                   | -                                      |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү               | -                               | -                     | -                   | -                                      |
| D08 | Тайлант үеийн үр дүн                             | -                               | -                     | 1,029,998.12        | 1,029,998.12                           |
| D09 | <b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>     | <b>1,599,496.00</b>             | <b>320,321.95</b>     | <b>1,029,998.12</b> | <b>2,949,816.07</b>                    |

**4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

| Дансны код  | Үзүүлэлт   | Өмнөх оны гүйцэтгэл  | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|----------------------|-----------------------|
|             | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>  |                      |                       |
| <b>1</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>  | <b>62,317,200.00</b> | <b>61,206,900.00</b>  |
| <b>13</b>   | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>   | <b>62,317,200.00</b> | <b>61,206,900.00</b>  |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>   | 4,000,000.00         | 3,300,000.00          |
| 131104      | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,000,000.00         | 3,300,000.00          |
| <b>1320</b> | <b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>  | 58,317,200.00        | 57,906,900.00         |
| 132001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/  | 58,317,200.00        | 57,906,900.00         |
| <b>2</b>    | <b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>   | <b>62,317,200.00</b> | <b>61,206,900.00</b>  |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | <b>62,317,200.00</b> | <b>61,206,900.00</b>  |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>   | <b>58,034,577.11</b> | <b>56,112,367.00</b>  |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>   | 44,140,179.95        | 41,134,262.29         |
| 210101      | Үндсэн цалин   | 24,843,567.07        | 25,049,181.72         |
| 210102      | Нэмэгдэл   | 10,915,925.62        | 10,295,987.57         |
| 210103      | Унаа хоолны хөнгөлөлт  | 466,120.00           | -                     |
| 210104      | Урамшуулал   | 7,914,567.26         | 5,789,093.00          |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>  | 5,465,997.16         | 5,333,004.71          |
| 210201      | Тэтгэврийн даатгал   | 3,804,753.55         | 3,720,702.20          |
| 210202      | Тэтгэмжийн даатгал   | 408,918.31           | 411,397.44            |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал  | 335,808.63           | 329,117.93            |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал   | 93,783.88            | 74,319.51             |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал  | 822,732.79           | 797,467.63            |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>  | 3,017,400.00         | 2,478,400.00          |
| 210401      | Бичиг хэрэг  | 613,100.00           | 425,300.00            |
| 210402      | Тээвэр, шатахуун   | 2,176,200.00         | 1,841,100.00          |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр   | 138,100.00           | 140,000.00            |
| 210405      | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал  | -                    | 72,000.00             |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс  | 90,000.00            | -                     |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>   | 420,000.00           | -                     |
| 210602      | Тавилга  | 420,000.00           | -                     |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>  | 626,000.00           | 657,000.00            |
| 210702      | Дотоод албан томилолт  | 626,000.00           | 657,000.00            |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>  | 4,305,000.00         | 3,549,700.00          |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж                                       | 3,981,000.00         | 3,225,700.00          |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>   | 60,000.00            | 2,960,000.00          |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх  | 60,000.00            | 2,960,000.00          |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | <b>4,282,622.89</b>  | <b>5,094,533.00</b>   |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>  | 990,000.00           | 1,310,000.00          |

|             |   |              |              |
|-------------|---|--------------|--------------|
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал<br>урамшуулал                                      | 990,000.00   | 1,310,000.00 |
| <b>2133</b> | <b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт,<br/>шилжүүлэг</b>                          | -            | 3,610,033.00 |
| 213303      | Төвлөрүүлэх шилжүүлэг   | -            | 3,610,033.00 |
| <b>2134</b> | <b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн<br/>захирагчдад олгох татаас, санхүүжилт</b> | 3,292,622.89 | 174,500.00   |
| 213403      | Төвлөрүүлэх шилжүүлэг   | 3,292,622.89 | 174,500.00   |
| <b>8</b>    | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ<br/>(8)=(3)+(6)+(7)</b>                            | -            | -            |
| <b>9</b>    | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний<br/>үлдэгдэл</b>                     |              | -            |
| <b>10</b>   | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн<br/>үлдэгдэл</b>                    | -            | -            |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт   | Тайлант оны           |                      |                     |
|-----------------------|--|-----------------------|----------------------|---------------------|
|                       |  | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл            | Зөрүү               |
| <b>2</b>              | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                             | <b>57,906,900.00</b>  | <b>54,296,867.00</b> | <b>3,610,033.00</b> |
| <b>21</b>             | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | 57,906,900.00         | 54,296,867.00        | 3,610,033.00        |
| <b>210</b>            | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                               | 57,740,300.00         | 54,136,867.00        | 3,603,433.00        |
| <b>2101</b>           | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                             | 44,231,100.00         | 41,134,262.29        | 3,096,837.71        |
| 210101                | Үндсэн цалин   | 24,549,700.00         | 25,049,181.72        | (499,481.72)        |
| 210102                | Нэмэгдэл   | 11,261,200.00         | 10,295,987.57        | 965,212.43          |
| 210104                | Урамшуулал   | 8,420,200.00          | 5,789,093.00         | 2,631,107.00        |
| <b>2102</b>           | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>                | 5,528,900.00          | 5,333,004.71         | 195,895.29          |
| 210201                | Тэтгэврийн даатгал   | 3,759,700.00          | 3,720,702.20         | 38,997.80           |
| 210202                | Тэтгэмжийн даатгал   | 442,300.00            | 411,397.44           | 30,902.56           |
| 210203                | ҮОМШӨ-ний даатгал  | 353,900.00            | 329,117.93           | 24,782.07           |
| 210204                | Ажилгүйдлийн даатгал   | 88,400.00             | 74,319.51            | 14,080.49           |
| 210205                | Эрүүл мэндийн даатгал  | 884,600.00            | 797,467.63           | 87,132.37           |
| <b>2104</b>           | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                              | 2,045,600.00          | 1,884,900.00         | 160,700.00          |
| 210401                | Бичиг хэрэг  | 516,500.00            | 425,300.00           | 91,200.00           |
| 210402                | Тээвэр, шагахуун   | 1,268,500.00          | 1,247,600.00         | 20,900.00           |
| 210403                | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                                   | 188,600.00            | 140,000.00           | 48,600.00           |
| <b>2107</b>           | <b>Томилолт, зочны зардал</b>  | 689,800.00            | 657,000.00           | 32,800.00           |
| 210702                | Дотоод албан томилолт  | 689,800.00            | 657,000.00           | 32,800.00           |
| <b>2108</b>           | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | 2,280,100.00          | 2,167,700.00         | 112,400.00          |
| 210801                | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,956,100.00          | 1,843,700.00         | 112,400.00          |
| <b>2109</b>           | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                               | 2,964,800.00          | 2,960,000.00         | 4,800.00            |
| 210902                | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                    | 2,964,800.00          | 2,960,000.00         | 4,800.00            |
| <b>213</b>            | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | 166,600.00            | 160,000.00           | 6,600.00            |
| <b>2132</b>           | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>  | 166,600.00            | 160,000.00           | 6,600.00            |
| 213209                | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                              | 166,600.00            | 160,000.00           | 6,600.00            |
|                       | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                                | <b>57,906,900.00</b>  | <b>54,296,867.00</b> | <b>3,610,033.00</b> |
| <b>1320</b>           | <b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                                | 57,906,900.00         | 54,296,867.00        | 3,610,033.00        |
| 132001                | Орон нутгийн төсвөөс   | 57,906,900.00         | 54,296,867.00        | 3,610,033.00        |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код  | Үзүүлэлт   | Гүйцэтгэл           |
|-------------|--|---------------------|
|             | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл   |                     |
| <b>I</b>    | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>   | <b>3,300,000.00</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | <b>3,300,000.00</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>   | 1,975,500.00        |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>  | 593,500.00          |
| 210402      | Тээвэр, шатахуун   | 593,500.00          |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>  | 1,382,000.00        |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж                                       | 1,382,000.00        |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | 1,324,500.00        |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>  | 1,324,500.00        |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал  | 1,150,000.00        |
| <b>II</b>   | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>  | <b>3,300,000.00</b> |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>   | 3,300,000.00        |
| 131104      | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,300,000.00        |

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Баянмөнх сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Туяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн Баянмөнх сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 7 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хэнтий аймгийн Баянмөнх сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын чиг үүргийг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд “Сум, дүүргийн Хурал нь Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, яам, агентлаг, дээд шатны Хуралд болон төрийн эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтанд хуулиар харьяалуулснаас бусад тухайн нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн болон зохион байгуулалтын ямар ч асуудлыг хэлэлцэж бие даан шийдвэрлэх эрхтэй бөгөөд дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж хэрэгжүүлнэ: 18.1.1. Хурлын зохион байгуулалт, хяналт шалгалтын талаар, 18.1.2. нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн талаар, 18.1.3. орон нутгийн өмчийн талаар, 18.2. Хуулиар тусгайлан эрх олгогдсон тохиолдолд захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлж, мөрдүүлнэ, 18.3. Сум, дүүргийн Хурал нь хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна

Хэнтий аймгийн Баянмөнх сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хэнтий аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас Баянмөнх сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит гүйцэтгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хэнтий аймгийн Баянмөнх сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 60.7 сая төгрөгөөс 1 хувиар буюу 0.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 0.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хэнтий аймгийн Баянмөнх сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 6.6 сая төгрөг болж, өмнөх оноос 1.0 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, хуримтлагдсан үр дүнгийн данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөг/

| Үзүүлэлт  | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт   |
|---|----------------|-----------------|------------|
| Б   | 1              | 2               | 3=2-1      |
| Мөнгөн хөрөнгө                                    | -              | -               |            |
| Авлага  | -              |                 | -          |
| Урьдчилгаа  | 0.6            |                 | (0.6)      |
| Бараа материал                                    | 2.9            | 5.1             | 2.2        |
| Үндсэн хөрөнгө                                    | 2.1            | 1.5             | (0.6)      |
| <b>Нийт хөрөнгө</b>                               | <b>5.6</b>     | <b>6.6</b>      | <b>1.0</b> |
| Өр төлбөр   | -              |                 | -          |
| Засгийн газрын оруулсан капитал                   | 1.6            | 1.6             | -          |
| Хуримтлагдсан үр дүн                              | 3.7            | 4.7             | 1.0        |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                  | 0.3            | 0.3             | -          |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b> | <b>5.6</b>     | <b>6.6</b>      | <b>1.0</b> |

Урьдчилгаа дансны үлдэгдэл 0.6 сая төгрөгөөр буурсан өмнөх онд худалдан авалт хийж урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн материалыг тайлант онд орлогоор бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 5.1 сая төгрөг болж, 2.2 сая төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн данснаас тайлант онд 0.1 сая төгрөгийн номыг бараа материалын дансанд шилжүүлж, 0.5 сая төгрөгийн элэгдэл тооцож, 1.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4.7 сая төгрөг болж, 1.0 сая төгрөгөөр буюу тайлант үеийн үр дүнгээр өссөн байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 1.0 сая төгрөгөөр буюу 1.6 хувиар өссөн нь өмнөх дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 0.7 сая төгрөгөөр, урсгал үйл ажиллагааны санхүүжилт 0.3 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал 60.2 сая төгрөг болж өмнөх оноос 0.5 сая төгрөгөөр буюу хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бүх урсгал зардлууд нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 93.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 36.0 сая төгрөгөөр бууруулан 57.9 сая төгрөгөөр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 57.9 сая төгрөгийн төсөв баталсныг орон нутгийн төсвөөс 57.9 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 57.9 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 54.1 сая төгрөгийг зарцуулж 3.8 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 3.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж зарцуулсан байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.7.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансны сайтад оруулбал зохих мэдээллийг хуулийн хугацаанд, иж бүрэн, үнэн зөв мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байна гэж дүгнэлээ.

### **3.9 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

#### **3.10 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар батлагдсан төсвийн хүрээнд тэвчиж болох 2898.3 мянган төгрөгийг хэмнэж ажиллаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

### **4.2 Албан шаардлага**

Аудитаар залруулагдаагүй 2.9 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. МУ-ын Засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалтын дагуу батлагдсан төсвийн хүрээнд тэвчиж болох 2898.3 мянган төгрөгийг хэмнэж ажиллаагүй байна.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

| Д/д  | Аудитад хамрагдсан байгууллагын нэр                        | Нийт алдаа, зөрчлийн |            | Үүнээс    |     |               |     |                 |     |          |            |          |  |
|--|--|----------------------|------------|-----------|-----|---------------|-----|-----------------|-----|----------|------------|----------|--|
|  |  |                      |            | Залруулга |     | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж  |            |          |  |
|  |  | Тоо                  | Дүн        | Тоо       | Дүн | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо      | Дүн        |          |  |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудал                            |  |                      |            |           |     |               |     |                 |     |          |            |          |  |
| 1  | Хэнтий аймгийн Баянмөнх сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал | 1                    | 2.9        |           |     |               |     |                 |     | 1        | 2.9        |          |  |
|  | <b>Дүн</b>   | <b>1</b>             | <b>2.9</b> |           |     |               |     |                 |     | <b>1</b> | <b>2.9</b> |          |  |
| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал |  |                      |            |           |     |               |     |                 |     |          |            |          |  |
| 1  | Хэнтий аймгийн Баянмөнх сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал |                      |            |           |     |               |     |                 |     |          |            |          |  |
|  | <b>Дүн</b>   |                      |            |           |     |               |     |                 |     |          |            |          |  |
|  | <b>Нийт дүн</b>  | <b>1</b>             | <b>2.9</b> |           |     |               |     |                 |     | <b>1</b> | <b>2.9</b> | <b>1</b> |  |

**6. Аудитын тайлангийн хавсралт**

6.1. Албан шаардлага 2021.03.04 №01

ХЭА-2022/57/НА-СТА-ТШЗ



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 04

Дугаар 62/А2370447  
ХТН-2022/57/НА-СТН-ТЦЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Баянмөнх сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Батлагдсан төсвийн хэмжээнд тэвчиж болох 2.9 сая төгрөгийг хэмнэж ажиллаагүй байна.

Энэ нь Монгол улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1 дугаар зүйлийн 1.1-д “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”, 1.5 “салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх” гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.


Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянмөнх сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга О.Батбаатар, нягтлан бодогч Х.Амаржаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР



Н.ТУЯА

Д.ОЮУНТУЯА

02303032